

БАТЛАВ

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Д.ОЮУНЦЭЦЭГ

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 6 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

НИЙТ 20 ОНОО

ХУВИЛБАР А

ХУГАЦАА 60 МИНУТ

6...ангийновогтой сурагч

ЭХИЙГ УНШААД ДАРААХ ДААЛГАВРЫГ ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.

Есдүгээр сарын нэгэн

Наран гараа тосно.

Манай сургуулийн давхар цагаан байшин, алаг цэцэгсийн давалгаа мэт хүүхэд багачууд, Бор багш бүгд л алган дээр минь багтана. Баасандорж бид хоёр баяр хөөртөө багтаж ядан зогсов. Аавын авч өгсөн цүнх шинэхэн номоор дүүрэн байв. Энэ жил дүү минь сургуульд орж байгаа болохоор би дүүтэйгээ хамт сургууль руугаа баяр бахдал дүүрэн алхаж явлаа.

Бид хоёрыг сургуульдаа явж байх замд манай захирал Очирбат багш маань тааралдаад миний дүүгийн толгойг энхрийлэн илж “Энэ Баасандоржийг хараач ээ, цүнхнээсээ өндөргүй юм, яг л нэмэх тэмдэг дээ” гэв. Чухам нэмэх тэмдэг гэсний учрыг тэр үед ойлгоогүй ч дотроо бол сумын сургууль нэг сурагчаар нэмэгдэж байгаа гэж бодож явсан юм.

Тэртээх хөх тэнгэрийн уудмаар галуун цуваа өнгөрлөө. Бас л сургуульдаа явж байгаа биз ээ гэсэн сонин бодол төрөв. Ганганан гунганах дуу нь сэрүүн тунгалаг агаарыг хөглөнө. Сэтгэл дотор ариусаад яг л тэнгэрийн уужим цээлд нисэж яваа галуу шиг санагдаж билээ.

Хонх жингэнэнэ.

Холхи алсад биднийг даллан дуудна.

1. Ах дүү хоёрын баярласны учир юу вэ? \ 2 оноо \

.....
.....

2. Алаг цэцэгсийн давалгаатай юуг адилтгасан бэ? \ 2 оноо \

.....
.....

3. “Манай сургуулийн давхар цагаан байшин, алаг цэцэгсийн давалгаа мэт хүүхэд багачууд, Бор багш бүгд л алган дээр минь багтана.” гэсэн өгүүлбэрт байгаа жинхэнэ нэрсийг ялган бичнэ үү. \ 2 оноо \

.....
.....

4. “Ганганан гунганах дуу нь сэрүүн тунгалаг агаарыг хөглөнө.” гэсэн өгүүлбэрт байгаа үйл үгийг тусах ба эс тусах шинжээр нь ялган бичиж тайлбарлана уу. \ 2 оноо \

Тусах үйл үг	Эс тусах үйл үг


5. “ давхар, тэнгэр, уудам, бахдал, тэмдэг “ зэрэг үгсэд харьяалахын тийн ялгалын нөхцөлийг залгаж бичээрэй. \ 2 оноо \
-
-

6. Зохиолын нэрийг зохиолын агуулгатай зөв харгалзуулна уу? /5 оноо/

- | | |
|--|--|
| 1. Л.Одончимэг “Хүүхдийн бор” өгүүллэг | А. Өндөр уулсыг даван, өргөн далай дээгүүр |
| 2. П.Хорлоо “Алт мөнгө хоёр” өгүүллэг | Б. Эрлэг Номун хааны, эд баялагийн тэнгэр.. |
| 3. Лакшмын соёрхол | В. Бүжигчин хүн харвал уран хөдөлгөөний |
| 4. Кейко Тани “Цаасан онгоцны үлгэр” | Г. Унтахаар нөмөртэй газар олоод, ахыгаа... |
| 5. Ч.Лодойдамба “Шаргачин” өгүүллэг | Д. Гэтэл манай нутагт нэгдэлжих хөдөлгөөн... |

А.1а,2д,3б,4в,5г. Б.1д,2г,3б,4а,5в. В.1в,2а,3б,4г,5д. Г.1а,2д,3в,4б,5г.

7. Дараах эхийг кирилл рүү хөрвүүлээрэй. \ 5 оноо \



БАТЛАВ

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Д.ОЮУНЦЭЦЭГ

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 6 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

НИЙТ 20 ОНОО

ХУВИЛБАР В

ХУГАЦАА 60 МИН

6....ангийновогтой сурагч

ЭХИЙГ УНШААД ДАРААХ ДААЛГАВРЫГ ГҮЙЦЭТГЭЭРЭЙ.

СҮХ ХҮҮ

Сүх өглөө эртлэн босно.тэгээд ээждээ зомгол түүж авчирч өгөх буюу хусны үйс гал асаахад нь тусална.Тэгэхэд ээж нь баярлан хүүгийнхээ зулайг илнэ.Шөмбөгөрхөн нүүртэй эелдэгхэн зантай, хүрэн бор царайтай Сүх хүү өдөр бүр хоёр бор авдрынхаа дундан модон шургуулган дээрх модон морь гүнгэрваа бүхий Дарь эх бурхныг гялалзтал арчина.Тэгснээ хэдэн модон тагшаа угааж өрж тавина.

Нэг өдөр ээжийнхээ цай уудаг шаазанг угааж байгаад хагалчихав. Сүх “Яана даа! ээжийн минь цай уудаг ганц шаазан гэж харуусан бодохын зуур,бяцхан хар нүдийг нь нулимс бүрхэн хэрхэх учраа олохгүй хий л сандрав.Тэгээд ээжийнхээ үйлний гурилаас хагархайд нь түрхэн нийлүүлбэл дорхноо салж ойчлоо.Ээж нь орж ирэв.

- Ээжээ! Та намайг бүү аашлаарай, би нэг хэрэг хийсэн гэлээ.Миний хүү ямар хэрэг хийснээ хэл, ээж нь сонсьё гэхэд Сүх ,

- Таны цай уудаг шаазанг угааж байгаад тулган дээр алдаад хагалчихлаа яана аа? гэж үнэнээ хэлэв.

Ээж нь за яах вэ, миний хүү бүү сэтгэл зов. Шаазан олдоно биз! .Үнэнээ хэлсэн чинь сайн байна.Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ гэдэг юм гэлээ.Ээжийгээ харахад хөрслөг бор нүүр нь туяаран, нэг л өнгө орсон юм шиг баяр жавхаа тодрон гэрэлтэж байлаа.

1. Эхийг эхлэл, гол, төгсгөл хэсгээр нь ялгаж, тус бүрд юуны тухай өгүүлснийг хураангуйлж бичээрэй. /2оноо/

Эхлэл хэсэг:

Юуны тухай өгүүлсэн

Гол хэсэг:.....

Юуны тухай өгүүлсэн.....

Төгсгөл хэсэг:

Юуны тухай өгүүлсэн:.....

2. Ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас үгийн утгыг тайлбарлана уу? /2оноо/

Эелдэг зан.....

Тагш:.....

3. Сүх өглөө эртлэн босно.” гэсэн одоо цагийн утгатай өгүүлбэрийг ирээдүй болон өнгөрсөн цагийн утгатай болгон хувирган бичээрэй. /2 оноо/

Ирээдүй цагийн утга:.....

Өнгөрсөн цагийн утга:.....

4. Сүх өдөр бүр ээждээ тусална” гэсэн өгүүлбэрээс цөм өгүүлбэрийг ялгаж тодорхойлоорой. /2 оноо/

.....

5. Эзэнд хамаатуулах -аа нөхцөлийг зөв залгасан үгийг олоорой./2оноо/

А. Нөхөддөө б. Сурагчдадаа в. Ногоочиддоо г. Малчиддаа

6. Дараах зохиолыг зохиолын нэртэй нь зөв харгалзуулаарай. /5оноо/

1.Д.Равжаа

А.Миний эжий

2.Хуульч Сандаг

Б.Гурван сүлжээ

3.Д.Нацагдорж

В.Салхинд хийсэн хамхуулын үг

4.П.Бадарч

С.Аранзал зээрд

5.Ж.Дашдондог

Е.Есөн эрдэнийн орон

А.2в.3а.4е.5с.1б

Б.1б.2в.3а.4е.5с

С.4е.2в.1б.5с.3а

Д.5с.4е.3а.2в.1б

7. Кирилл бичигт буулгаарай. /5оноо/

